

Алексей Тенчой
Лам нарт тохиолдсон 43
гайхалтай түүхүүд



Алексей Тенчой

**Лам нарт тохиолдсон
43 гайхалтай түүхүүд**

«Издательские решения»

Тенчой А.

Лам нарт тохиолдсон 43 гайхалтай түүхүүд / А. Тенчой —
«Издательские решения»,

ISBN 978-5-44-901872-4

Энэхүү номыг уншсанаар та бүхэн өнгөрсөн болон өнөө цагийн агуу лам багш нарын түүхтэй танилцах болно. Энд өгүүлэх түүх нь Дорнын гүн ухааныг сонирхогчдод болон олон түмэнд таалар болгоогдох буй за. Энэхүү өгүүлэг үлгэр домогийг эрхэм уншигч та мэргэн оюундаа таашаан болгооно уу.

ISBN 978-5-44-901872-4

© Тенчой А.
© Издательские решения

Содержание

Балбар лам нохой хоёр	6
Богд гэгээн Соп лам хоёр	8
Конец ознакомительного фрагмента.	9

Лам нарт тохиолдсон 43 гайхалтай түүхүүд

Алексей Тенчой

© Алексей Тенчой, 2017

ISBN 978-5-4490-1872-4

Создано в интеллектуальной издательской системе Ridero

Балбар лам нохой хоёр

*Хүн өөрийн хүсэл шуналаас татгалзаж,
Өөрийн БИ —г номхотгож байвал
Тэр өөрөө өөрийнхөө эзэн нь болж
Өөрийн БИ-г олно.*

Будда Шагжамун.

Бурядын ард түмэнд төвдийн анагаах ухаанаар анагаагч Балбар лам гэж хүн байдаг – Ямар маарамба гэж санана! Тэр бүх л амьдралаа эмчлэх шинжлэх ухаанд суралцаж байгаа нэгэн. Мөн тэрээр 253 тэр дундаа гэрлэхгүй, ганц бие явах сахил саваар хүртсэн Буддын шашны лам, – гэлэн хүн юм.

Улааны комиссарууд Сибирыг хэлмэгдүүлэн орж ирж тэдэнтэй санал зөрсөн хүмүүс ба шашны хүмүүсийг баривлах буюу буудан алж эхлэхэд Балбар лам хөрш Хятад орон руу явахаас өөр аргагүйд хүрэв. Тэнд тэрээр хүмүүсийг үргэлжлүүлэн эмчлэх буюу өөрийн тангарагыг хатуу дагаж байв. Хятадад ч коммунистууд эрх мэдлийг гартаа авсан цаг үе ирэхэд зугтах газар үгүй болов. Шинэ засаг бүх шашин шүтлэгийг худал хуурмаг зүйл харин шашны хүмүүсийг «хөдөлмөрч ард түмний дайсан» гэж зарлав. Энэ бүхнийг энгийн ард олон урьд нь шашин шүтлэгт ямар хүч, хайр, итгэлээр хандаж байсан шиг коммунист удирдагч нарт тийм байдлаар итгүүлэхийн тулд хийжээ. Балбар лам өөртөө тустай байшин барин амьдарч, тэндээ залбирал уншин цаг хугацааг өнгөрөөдөг болов. Өөртөө анхаарал татуулахгүй нь тулд тэр тахилаа нуужээ, харин залбиралаа тэр тэгэхдээ тэргүй цээжээр мэддэг байлаа.

Нэгэн өдөр хятадын коммунистууд түүн дээр ирж түүнийг «дайсны шашин шүтлэгийг» шүтдэггүй гэдгээ батлахыг шаарджээ.

– Чи яагаад энд ганцаараа амьдарч байгаа юм? Чи гэрлэхгүй, ганц бие явах тангарагаа дагсан хэвээр л байна уу? Гэж хятадын коммунист ёжлон асуухад

– Үгүй ээ. Гэрлэе гэж хүссэн ч царай муутай юм байлгүй нутгийн нэг ч бусгүй надтай хамт амьдрахыг хүсэхгүй байна. Гэж Балбар лам хариулав.

– Гэр бүлтэй болоход чинь чамд нэг сарын хугацаа өгье, тэгэхгүй бол буудуулах болно шүү гэж түүнд ууртай санууллаа.

Балбар лам бодолд дарагдлаа. Ламын сан санваар хүртэж байхдаа тэр гэр бүлтэй болохгүй, гэр бүлийн эцэг хүнд зайлшгүй тохиолддог зөвхөн өөрийн гэр бүлийн ашиг сонирхлын төлөө биш харин хүн бүхний төлөө адил зүтгэнэ гэж тангарагласан билээ. Бодолд дарагдсан чигтээ тэр өөрийн олон хүүхэдтэй хамаатан руугаа явлаа.

– Ах минь надад хэлээч! Та ийм олон хүүхэдтэй хүн, энэ хэцүү үед тэднийг тэжээх их л хэцүү байхдаа

– Харин тиймээ! Бид нар 70 үхэртэй байсан, коммунистууд «Ядуу хүмүүс идэх юмгүй байхад чи бусдаас баян амьдарч байна» гэж хэлээд л бүгдийг нь аваад явсан. Өөрсдөө миний малаар цэргээ хооллосон байж таарах вий. Бидэнд хамгийн муу үнээг үлдээсэн, тэр нь сүү ч өгөхгүй шүү. Би одоо хүүхдүүдээ яаж тэжээх болж байна? Яаж турсныг нь хар л даа, нүд л үлдсэн байгаа биз – гэж ах нь зовлонгоо хуваалцав.

– Би танаас нэг юм гуйх гэсэн юм. Надад нэг хүүгээ өгөөч. Би өөрөө хүүхэдгүй хүн, харин нэг хүүг би хооллож бас сургаж чадна шүү.

– Нэг гэр бүл юм чинь чи ав ав – гэж ах нь зөвшөөрөв.

Балбар лам бүх хүүхдүүдийг цуглуулаад өөрийн өргөмөл шавь-хүүгээ сонгож эхлэв. Тэр хамгийн хүчтэйг нь биш харин нүд нь хамгийн гал цогтойг нь сонгож авав.. Түүнийг Жимба – өглөг гэдэг утгатай нэртэй хүү байв. Хэр сэргэлэн хүү вэ гэдгийг баттай мэдэхийн тулд тэр түүнийг шалгахаар шийдэв.

– Хүүхдүүдээ миний таалгасан тааврыг таагаарай: «Нэг гэр бүлийн гурван охины нэгийг гэргийгээ болгохоор хүргэн болох залуу ирэв. Тэгээд тэднийг яг адил данханд, адил таглаатай бас адил хэмжээний усаар цай чанахыг санал болгов. Хэний цай түрүүлж буцалсаныг нь гэргийгээ болгоно гэв. Хэн түрүүлж цайг чанасан бэ: том, дунд эсвэл бага охин уу? Яагаад?» гэв.

Хүүхдүүд таамаглаж эхлэхэд ганцхан Жимба шууд л: Бага нь гэж хариулав.

– Яагаад?

– Яагаад гэвэл том охин нь байнга л таглааг нь авч данх руу хараад байсан, дунд охин нэг л удаа харсан, харин бага охин эгч нарынхаа замд саад болохгүй гээд тайван суусаар байсан. Таглаа авснаар уур нь замхарч ус удаан буцалсан гэв.

Ингээд Жимба Балбар ламынд амьдрах болов.

Сарын дараа шалгах хүмүүс хүрч ирэв.

– Чи соёлч хувьсгалтай яаж хөл зэрэгцэн явна? Манай агуу их Маог хэн ч хуурч байгаагүй шүү гэж ирсэн хүмүүс сүрдүүлж байв.

– Тиймээ тийм. Би та нарын зөвлөгөөг даган гэр бүлтэй болохоор шийдсэн. Эхнэр ологүй ч хүүтэй болсон шүү гээд бяцхан Жимба руу заав.

Тэд түүн рүү хараад итгэсэн болоод гараад явав. Эсвэл зүгээр л түүнийг анхаарах сүүхээ байгаагүй байх. Залуу улс орны эрх ашгийн төлөө өөр бас их баялгийг ард түмнээс хураах ёстой, тэгээд ч «дахин хүмүүжүүлэх» дараалалд баян байсан хүмүүс, багш болон шашны хүмүүс бүгдээр зогсож байв.

Ингээд Балбар лам өвс, танаар зовж шаналж байгаа хүмүүсийг эмчилж өөрийн бүх л амьдралаа хатуу чанга ёс жаягтай өнгөрөөсөн юм.

Харин төрсөн Буряд оронд хийд дацанг сэргээж эхлэхэд, эх оронд нь түүний амь насанд аюул тулгарахгүйг Балбар лам ойлгоод туслахаар эргэн ирэв. Нэгэн өдөр түүнийг болон нэр хүндтэй хэдэн төвд лам нарыг нэгэн хөрөнгө чинээлэг гэр бүлд ном уншуулахаар урив. Лам нар өөрсдөө товолсон газраа хүрэлцэн ирэхээр тохиролцов. Тэд ирэхэд хашаан дотор нэг дайрдаг нохой хуцаж, шүлсээ гойжуулж бас шүдээ хавирч гарлаа. Нэр хүндтэй лам нарын хэн нь ч хашаа руу орж зүрхлэхгүй зогсоцгоолоо. Балбар лам ирээд лам нар луу харчихаад хаалга онгойлгоод байшин руу явав. Нохой түүнийг харангуутаа дуугаа намсгаж чимээгүй болов. “Зам чөлөөтөй боллоо» гэж хүмүүс бодсон ч андуурчээ. Хүмүүс хашаанд оронгуут нохой гэрийн эзэгтэй түүнийг хорьтол тэдэн лүү дайрч гарлаа.

Зочид Балбар ламыг гайхлаа, дараа нь бүх л насаа ариун дагшин байдалд өнгөрөөсөн хүн ямар их хүчийг олж авдгыг ойлгоцгоолоо. Харин өргөмөл Жимба хүү энэ явдлын ачаар Оросод боловсрол олж аваад дараа нь Балбар ламаас өвс, танаар эмчлэх арга ухааныг сурч одоо хүмүүсийг эмчилдэг болсон юм.

Богд гэгээн Соп лам хоёр

*Майдар бурхны хөшөөг барих нь – зорилго биш.
Энэ нь зорилгодоо хүрэх арга зам юм.
Зорилго бол боломжтой бүхий л цаг хугацаа
Энэ урт цаг хугацааны үргэлжлэх явцад
Боломжтой хичнээн хүн байна Төдий чинээ хүнд
Ач тус хүргэх явдал юм.*

Сона лам.

Нэгэн үе Дээрхийн гэгээнтэн Богд гэгээний туслах нь би байсан юм.

Дээрхийн гэгээнтэн Богд гэгээн бол өндөр настай байсан ч өөрийн өндөр насыг харгалзахгүйгээр өөдрөг буюу чадалтай нэгэн байсан юм. Түүний хажууд өөрийгөө нялх хүүхэд аятай санаж сандрал, санаа зовох болон айдас мэдрэгдэхгүй ямар нэгэн хүчтэй хамгаалалтын бүсэд байгаа юм шиг мэдрэмж төрдөг байв.

Дээрхийн Гэгээнтэн Богд гэгээн нь бүх хүмүүсийг баяр баясалтайгаар угтдаг. Тэр мөргөлчдөд санаа тавьж тэдний төлөвлөгөө болон аялалыг сонирхож, Дарамсалаар хийх аялалыг зохион байгуулахад туслахыг санал болгодог доо. Энэ хүн Буддын шашинд ач холбогдлоороо хоёр дахь хүн хэдий ч түүнтэй харьцахад энгийн бас хялбар байдаг. Тэр их сайхан сэтгэлтэйгээс гадна түүний байгаа байдалд өөрийгөө онцгой гэж цухуйлгах нэг ч зүйл байдаггүй.

Багш шавь нарын уулзалт яаж явагддагыг би дандаа сонирхдог байсан. Хүн бүхэн – нэг дор багш бас шавь байдаг. Хэрвээ Багш нь зөвийг ухаарах хэмжээнд хүрсэн бол тэр түүнийгээ хажуугаас мэдрэгдэхгүй маш өвөрмөц, гэхдээ шавь нь тэрийг маш хүчтэй мэдэрдэг үйлчилгээтэй аргаар дамжуулдаг. Би Богд гэгээнийг харж байхдаа энгийн өдөр тутмын амьдралд Бодхичиттын ойлголт (Бүх л амьд биетийн сайн сайхны төлөө гэгээрэлд хүрэхэд чиглэгдсэн ухамсар) ямар их ач холбогдолтойг ойлгож эхэлж байв. Энэ нь ямар ч дүн тавихгүй, сайн муу гэсэн ялгаагүй, өөрийнх хүнийх гэхгүйгээр нээлттэй, хайр сайхан сэтгэл, халамж болон өрөвдөх сэтгэлээр хүмүүст хандах хандлага юм. Үүнд л хүмүүсийн ихэнх хэсэг шаналж байдаг «хоёр хуваагдах», хоёрдмол байдлыг даван туулах хүч илэрдэг.

Мэдээж хэрэг хүмүүстэй ийм маягаар харьцаж сурсан хүний амьдралыг ажиглах нь өөртөө энэ чанарыг хөгжүүлэхэд хангалтгүй. Гэхдээ ийм хүнтэй харьцах нь өөрөө өөрөөсөө: «Би хэн бэ?» гэж асуух, амьдрал ба тойрон хүрээлж буй хүмүүст хандах хандлагаа дүгнэхэд хүргэдэг түлхэц болж өгдөг. Тэр нь хүмүүсийг бүхий л муу дадлаасаа салж аз жаргалтай байхыг сургаж, гүн ухааны хүнд асуултуудыг ойлгоход хялбар, хүртээлтэй хэлээр тайлбарладаг юм. Өөрийн амьдрал болон хүмүүст хандах хандлага, амьдрах хүсэл эрмэлзэл, хүмүүст өөрийн амьдралын замаа олоход ба өөртөө буддаг хөгжүүлэхэд тус болдгоороо тэр бидэнд үлгэр жишээ болдог. Үүгээрээ тэр миний хувьд Багш минь болсон.

Бас нэг гайхалтай зүйл нь би нэг ч удаа түүнийг буддизмын суртал ухуулга, шүтлэг бишрэлийн ялгааны тухай үг цухуйлгаж байгааг сонсоогүй явдал. Би аман дээрээ биш харин бодит байдалд ямар итгэл үнэмшилтэйг харгалзахгүйгээр тэвчээртэй байх бүх л хүмүүсийг хүлээн зөвшөөрхийг харсан юм. Өөртөө дээд хүчийг мэдэрч байхад хүрч л байвал гэгээрэлд хүмүүсийг янз бүрийн замаар хүрэхийг зөвшөөрдөг байх. Мөн бурханы нигүүлсэлийг биднийг мэдрэхийг зөвшөөрдөг Гэгээрсэн хүмүүс манай дэлхий дээр амьдарч байдагт Багш нараа магтан сайшаая.

Конец ознакомительного фрагмента.

Текст предоставлен ООО «ЛитРес».

Прочитайте эту книгу целиком, [купив полную легальную версию](#) на ЛитРес.

Безопасно оплатить книгу можно банковской картой Visa, MasterCard, Maestro, со счета мобильного телефона, с платежного терминала, в салоне МТС или Связной, через PayPal, WebMoney, Яндекс.Деньги, QIWI Кошелек, бонусными картами или другим удобным Вам способом.